

2. Хилийн анги, отрядын удирдлага (алба, тасгийн дарга нар)-ын бүрэлдэхүүний удирдах ур чадварыг дээшлүүлэх, өөрчлөлт шинэчлэлийн үйл хэргийг хилийн анги, отрядод буулгаж, хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахад бэлтгэх.

3. Улсын хил дээр алба хааж байгаа хилчдийг мэргэшүүлэх, ялангуяа хууль сахиулагчийн төвшинд эрх зүйн мэдлэг, чадварыг олгоход чиглэсэн сургалтыг ойрын хугацаанд үе шаттайгаар зохион байгуулах зэрэг нь зүйтэй гэж үзэж байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
дэд хурандаа А.Сүхбаяр*

БАЙР ЗҮЙН ЗУРГААР ГАЗАР ОРОН ДЭЭР ЗҮГ ЧИГ ОЛЖ БАРИМЖААЛАХ

Цэргийн байр зүйн зургийг унших, түүнийг ашиглах нь өнөөдөр зөвхөн цэргийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын ажил, эзэмших мэргэжил, чадвар төдийгөөр хязгаарлагдахаа больжээ. Түүнчлэн луужин, GPS төхөөрөмжийг ашиглах нь цэргийн болон цэрэгжүүлсэн байгууллагын ажил бус хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжэд тодорхой хэмжээгээр шаардагдах болсон байна. Иймд байр зүйн зураг ашиглах, зүг чигээ зөв олох, луужинг чадварлаг ашиглаж сурах нь тухайн хүний аюулгүй байдлыг хангаад зогсохгүй олон талын ач холбогдолтой.

Цагийн байдалд тодорхой хэмжээний нөлөө үзүүлэх үндсэн элементүүдийн нэг нь газар орон юм. Газар орон дээр ба байр зүйн зургаар газар орныг зөв, хурдан үнэлж, түүн дээр баримжаалал хийж чаддаг байх шаардлагатай.

Газрын зураг гэж газрын гадаргын орон зайд байгаа бодит объект, биетүүдийг ямар нэгэн хавтгайд дүрслэн масштабт оруулан томъёолсон тэмдгээр дүрсэлсэн зургийг хэлнэ.

Газар зүйн нэр гэж газрын гадарга дээрх байгалийн болон барьж байгуулсан объектуудыг өөр хооронд нь ялган таних зорилгоор тогтоосон нэрийг хэлнэ. Газар зүйн нэрэн эх газар, далай, тэнгис, булан, тохой, арал, хойг, уул, нуруу, хээр, тал, говь, цөл, мөрөн, гол, нуур зэрэг физик газар зүйн объект мөн хүний үйл ажиллагаагаар бий болсон далан, усан сан, суваг, шуудуу, улс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тэдгээрийн доторх хөдөө аж ахуй, үйлдвэр, тээвэр, холбоо зэрэг бусад объектууд тус тус хамаарна.

Байр зүйн зураг түүн дээр ажиллахад дараах зүйлийг анхаарах хэрэгтэй:

- Зургийн масштаб, нэрэлвэр, хэвлэгдсэн он
- Зураг хэдэн оны агууллагатай болох тухай зургийн баруун доод буланд бичигдсэн тэмдэглэгээ
- Солбилцолын тогтолцоо ба өндрийн систем
- Үеийн өндөр, жинхэнэ голдоч ба соронзон голдоч, тэгш өнцөгт солбилцолын босоо сугамын торжилтын байрлалын бүдүүвч зэрэг болно.

Зургаар газар орон дээр зүг чиг олж баримжаалах ажиллагаа нь:

1. Зургийн зүг чигийг олох

2. Зураг дээр оорийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлох

3. Зургийг газар оронтой тохируулах зэргээс бүрдэнэ

Байр зүйн зургийг хуудас тус бүр нь трапец дүрстэй бөгөөд түүний дээд тал нь ертөнцийн хойт, доод тал нь өмнө, баруун гар тал нь зүүн, зүүн гар тал нь баруун зүгийг тус тус заана. Зургийн зүг чигийг олно гэдэг нь түүний дээд талыг ертөнцийн хойт зүг рүү, доод талыг өмнө зүг рүү харуулан зураг дээрх шулуун шугам бүхий томъёолсон тэмдгийг, тэдгээрийн газар орон дээрх жинхэнэ зүйлүүдтэй нь зэрэгцээгээр давхцуулан байрлуулна гэсэн үг юм. Зургийн зүг чигийг хоёр үндсэн нөхцөлд тулгуурлаж олно. Үүнд:

а/ орон нутгийн шулуун (зам, далан, суваг шуудуу, голын эрэг, ойн зах) тэмдэгтээр (ганц мод, хошөө, ганц чулуу, геодезийн тулгуурт цэг гэх мэт) орон нутагт тэдгээрийн тусламжтайгаар;

б/ ашиглах орон нутгийн шулуун шугам бүхий зүйлүүд байхгүй, тэмдэгтээр ховор газар оронд луужингийн тусламжтайгаар зургийн зүг чигийг тус тус олж тодорхойлно.



Орон нутгийн шулууны тусламжтайгаар зургийн зүг чигийг олох

Энэ аргаар зургийн зүг чигийг олж тодорхойлохын тулд зураг дээр дүрслэгдсэн бөгөөд газар орон дээрээ байгаа ямар нэгэн шулуун шугам бүхий зүйлийг сонгож авна. Дараа нь уг шулууныхаа зураг дээрх дүрслэлийг (томъёолсон тэмдэг) түүний газар орон дээрх жинхэнэ зүйлтэй нь зэрэгцээгээр давхцуулан байрлуулж, энэ шулуун шугам бүхий зүйлийнхээ баруун ба зүүн талд нь байгаа бодит зүйлүүдийн байрлалтыг зураг ба газар орон дээр харьцуулан жишиж үзнэ. Ингэхэд уг бодит зүйлүүдийн байрлалт нь зураг ба газар орон дээр тохирч байвал зураг зүг чигээ оллоо гэж үзнэ.

Хэрвээ бодит зүйлүүдийн байрлалт нь зураг ба газар орон дээр тохирохгүй байвал зургийг 80° эргүүлж бүх ажиллагааг шинээр давтан хийнэ.

Тэмдэгт сонгон авч чиглүүлэх аргаар зургийн зүг чигийг олох

Энэ арга нь өөрсдөө гүүр, замын уулзвар ба ганц мод, геодезийн тулгуурт цэг, ганц байшингийн дэргэд байрлан өөрийн зогсож байгаа цэгийг тодорхой мэдэх үед зургийн зүг чигийг олоход илүү тохиромжтой. Үүнд өөрийн зогсож байгаа цэгээс гадна зураг дээр дүрслэгдсэн газар орон дээр харагдаж байгаа ямар нэгэн тэмдэгтийг сонгож авна.



Жишээ нь: зураг дээр бидний зогсож байгаа цэг замын уулзвар, сонгож авсан

тэмдэгт нь ганц мод болж байна.

Тэмдэгт нь зураг дээр өөрийн зогсож байгаа цэг (замын уулзвар) ба сонгож авсан тэмдэгт (ганц мод) хоёрын томъёолсон тэмдгүүдийг дайруулан чиглүүлэгч шугам буюу харандааг зураг дээр байрлуулна.

Чиглүүлэгч шугам буюу харандааны байрлалтыг өөрчлөлгүйгээр зургийг эргүүлж газар орон дээрх жинхэнэ тэмдэгт рүү (жишээ нь ганц мод) чиглүүлэгч шугам буюу харандааг хараалан чиглүүлнэ.


Ингэхэд зураг ертөнцийн зүг чигийн дагуу байрласан байх ёстой. Байрласан эсэхийг нь шалгахын тулд өөр нэг тэмдэгтийг сонгон авч, зүг чигээ олсон зургийг хөдөлгөлгүйгээр чиглүүлэгч шугам буюу эсвэл харандааг өөрийн зогсож байгаа цэг, шинээр сонгож авсан тэмдэгт хоёрын томъёолсон тэмдгүүдийг дайруулан тавьж энэ чиглэлийн дагуу (шугам ба харандааны дагуу) шагайж үзнэ. Ингэхэд уг тэмдэгт харагдаж байвал зураг зүг чигээ олсны баталгаа болно.

Луужингийн тусламжтайгаар зургийг зүг чигийг олох

Луужингийн тусламжтайгаар зургийн зүг чигийг олохын тулд:

-луужинг тэг (0) диаметрээр нь жинхэнэ голдоч буюу зураг дээрх солбицлолын торын аль нэг босоо шугамын дагуу түүний хуваарийн тэг (0) цэгийг зургийн дээд тал руу харуулан байрлуулна.

Дараа нь зураг дээрээс зохих өнцгийн засварыг авч жинхэнэ голдоч ба эсвэл солбицлолын торын аль нэг босоо шугамын дагуу байрласан луужинг хөдөлгөлгүйгээр цоожлогчийг нь суллаж, луужинг зургийн хамтаар түүний зүү хойт үзүүрээрээ уг өнцгийн засварыг заах хүртэл эргүүлнэ. Ингэхэд зураг зүг чигээ олох ба Үүнд.



а/ хэрвээ луужинг тэг-диаметрээр нь торын босоо шугаманд байрлуулсан бол зураг дээрээс өгөгдсөн чиглэлийн засварыг авна.

б/ хэрвээ луужинг тэг-диаметрээр нь жинхэнэ голдчийн дагуу байрласан бол зураг дээрээс зөвхөн соронзон хазайлтыг авна.

Зураг дээр өөрийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлох

Энэ ажиллагаа нь заавал зургийн зүг чигийг олсны дараа хийгдэнэ. Хэрвээ бидний зогсож байгаа цэг гүүр, замын уулзвар гэх мэтийн тодорхой зүйл байвал, түүнийг хайлтгүй уг зүйлийн томъёолсон тэмдэг нь зураг дээр бидний зогсож байгаа цэг болно. Энэ арга нь зураг дээр өөрийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлох хамгийн хялбар бөгөөд үндсэн арга юм. Энэ аргаар өөрийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлохын тулд зургийн зүг чигийг олсны дараа өөрийгөө хүрээлэн байгаа газар орны байдлыг сайтар ажиглан газар орон дээр харагдаж байгаа, зураг дээр дүрслэгдсэн хоёроос доошгүй тэмдэгтийг сонгож авна. Дараа нь өөрөөсөө тэдгээр


тэмдэгтүүд хүртэлх зайг нүдэн баримжаа ба гарын доорхи материалыг ашиглан тодорхойлж энэ зайтайгаа уялдуулан газрын гадаргуун байдлыг харгалзан нүдэн багцаагаар өөрийн зогсож байгаа цэгийн зураг дээр олж тодорхойлно.

Явж өнгөрсөн зайг хэмжих аргаар өөрийн зогсож байгаа цэгийг тодорхойлох

Энэ аргаар зам, голын эрэг, ойн зах, далан зэрэг ямар нэгэн шулуун шугам бүхий зүйлийн дагуу буюу эсвэл тодорхой чиглэлд явж байгаа үед өөрийн зогсож байгаа цэгийг зураг дээр олж тодорхойлоход илүү тохиромжтой юм. Түүнчлэн хязгаарлагдмал үзэгдэлтэй нөхцөлд өгөгдсөн азимутаар явж байхад тохиромжтой. Ялангуяа үзэгдэлт муутай нөхцөлд далдлах ба хагас далдлах газар орон, тэмдэгтээр ховор газар оронд өөрийн зогсож байгаа цэгийг зураг дээр олоход энэ арга ашигтай.

Энэ аргаар өөрийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлохдоо анх эхэлж явсан цэг ба эсвэл өөр бусад газар орны ямар нэгэн тодорхой тэмдэгтээс явж өнгөрсөн зайг, уг зургийн хэмжээсийн дагуу зураг дээр хэмжин авч тодорхойлно.

Энэ аргаар өөрийн байрлалтыг тодорхойлоход анх эхэлж явсан цэг ба бусад тэмдэгтүүдийг зураг дээр найдвартайгаар тэмдэглэгдсэн бөгөөд газар орон дээрээ байгаа объектыг сонгож авах хэрэгтэй. Зайг хөдөлгөөн үйлдэж байгаа хэлбэрээс хамаарч хос алхмаар, километрээр ба хөдөлгөөний хугацаагаар хэмжинэ.




Хэд хэдэн шулууныг огтлолцуулах аргаар өөрийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлох

Энэ арга нь замгүй газраар буюу зураг дээр тэмдэглэгээгүй чиглэлд хөдөлгөөн үйлдэж байгаа үед өөрийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлоход илүү зохимжтой юм. Үүнд: зураг дээр дүрслэгдсэн бөгөөд газар орон дээрээ харагдаж байгаа гурваас доошгүй тэмдэгтийг сонгож авна.

Дараа нь зургийн зүг чигийг луужингийн тусламжтайгаар олж, зүг чигээ олсон зургийг хөдөлгөлгүйгээр тэмдэгт тус бүрийн зураг дээрх томъёолсон тэмдгийг дайруулан газар орон дээрх жинхэнэ тэмдэгт рүү нь чиглүүлэгч шугамыг хараалан чиглүүлж, түүний дагуу шулууныг татна. Ингэхэд эдгээр шулууны огтлолцлын нэг нь өөрийн зогсож байгаа цэг болно.

Энэ аргаар өөрийн зогсож байгаа цэгийг тодорхойлохдоо хоёр тэмдэгтийг сонгон авч болох юм. Гэхдээ гурав дахь тэмдэгтээс татсан шулуун нь шалгалтын шулуун болно. Мөн энэ аргаар өөрийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлохдоо 90° -д ойрхон өнцгөөр шулуунууд огтлолцохоор бодож тэмдэгтүүдээ сонгож авах нь зүйтэй. Иймд огтлолцлын өнцөг нь 30° -аас багагүй, 150° -аас ихгүй байх хэрэгтэй.



Калька иаасны тусламжтайгаар өөрийн зогсож байгаа цэгийг зураг дээр тодорхойлох

Энэ аргаар өөрийн зогсож байгаа цэгийг зураг дээр тодорхойлохын тулд шулуунуудыг огтолцуулах аргаар өөрийн зогсож байгаа цэгийг тодорхойлдгийн нэгэн адил хоорондоо хол зайтай байрласан 30° -аас багагүй, 150° -аас ихгүй өнцгөөр огтлолцох зураг дээр дүрслэгдсэн бөгөөд газар орон дээрээ харагдаж байгаа 3-аас доошгүй тэмдэгтийг сонгож авна.

-Дараа нь калька цаасыг авч түүнийг дэвтэр, ном офицер цүнх зэрэг ямар нэгэн хатуу зүйл дээр байрлуулж калька цаасны төвд нь юмуу эсвэл өөрийн бие талд ямар нэг дурын цэг хатгаж авна.

-Калька цаасыг хөдөлгөлгүйгээр түүн дээр сонгож авсан дурын цэгийг дайруулан чиглэлийн шугамыг газар орон дээрх тэмдэгт тус бүр лүү хараалан чиглүүлж шулууныг татна. Калька дээр татагдсан шулуун тус бүр ямар тэмдэгт рүү татагдсан болохыг мөн тэмдэглэж авна.

-Хараалсан чиглэлийн шулуунууд зурагдсан калька цаасыг байр зүйн зураг дээр тавьж, калька дээр зурагдсан шулуун тус бүр өөр өөрийн тэмдэгтийн томъёолсон тэмдгүүдийг нэг зэрэг дайрч өнгөрөх хүртэл калькыг эргүүлнэ.

-Калька цаасан дээр татагдсан шулуунууд өөр өөрийн тэмдэгтийн зураг дээрх томъёолсон тэмдгийг нэгэн зэрэг дайрч өнгөрөхөд, калькийг хөдөлгөлгүй анх калька дээр сонгож авсан дурын цэгийг зөвхөн калька цаасыг нэвтрэхээр хэмжигч ба зүүгээр нэвт хатгахад зураг дээр өөрийн зогсож байгаа цэг гарна. Нэгэнт зураг дээрх бүх зүйл калька цаасаар нэвт харагдаж байгаа болохоор өөрийн зогсож байгаа цэгийг тодорхойлохдоо заавал калькийг нэвт хатгах шаардлагагүй зүгээр нүдлээд авч болно.

Зургийг газар оронтой тохируулах

Энэ ажиллагаа нь зургийн зүг чигийг олж, зураг дээр өөрийн зогсож байгаа цэгийг олж тодорхойлсны эцэст аяндаа бий болсон байна. Зураг дээрх томъёолсон тэмдгүүдийн тусламжтайгаар жинхэнэ бодит зүйлийг нь газар орон дээр олж харах. мөн яг эсрэг газар орон дээрх бодит зүйлүүдийн байрлалтыг зураг дээр олж харах

замаар байр зүйн зураг дээр оронтойгоо хэр зэрэг тохирч байгааг шалган үзэж дүгнэлт хийх ажиллагааг зургийг газар оронтой тохируулах гэнэ.

Зургийг газар оронтой тохируулах ажиллагаа нь зүг чиг олж баримжаалах, хээрийн нөхцөлд зурагтай ажиллах үед заавал шаардагдана. Энэ ажиллагаа нь богино хугацаанд газар орныг бүрэн судлах, түүн дээр гарсан өөрчлөлтүүдийг илрүүлэх, хянаж ажиглаж байгаа тэмдэгт мэтийн чухал объектын байрлалтыг тодорхойлж, эдгээр нь газар орон дээр байгаа эсэхийг магадлах, тэдгээрийг хүртэлх зайг тодорхойлох зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэх боломжийг олгоно.

Газар орон дээр ажиглагдаж байгаа зүйлийн байрлалтыг зураг дээр олоход:

-Зургийн зүг чигийг олж, зураг дээр өөрийн зогсож байгаа цэгийг олох.

-Ажиглаж буй зүйл рүүгээ (тэмдэгт) нүүрээрээ харж зогсон өөрөөсөө уг зүйл хүртэлх зайг нүдэн баримжаа ба гарын доорхи материалыг ашиглан тодорхойлно.

-Зүгээ олж зургийг хөдөлгөлгүйгээр зураг дээр тодорхойлсон өөрийн зогсож буй цэгээ дайруулан чиглүүлэгч шугам эсвэл харандааг газар орон дээр ажиглагдаж байгаа бодит зүйл рүү чиглүүлж зөөлөн балтай харандаагаар шулуун татна.

-Зураг дээр татагдсан шулууны дагуу ажиглагдах зүйл хүртэлх зайг харгалзан тэр зүйлийнхээ томьёолсон тэмдгийг зураг дээр хайж олно. Энэ нь газар орон дээр ажиглагдаж байсан уг зүйлийн зураг дээрх байрлалт болно.

Зураг дээрх зүйлийн байрлалтыг газар орон дээр олж харах:

-Зургийн зүг чигийг олж, зураг дээр өөрийн зогсож байгаа цэгийг тодорхойлно.

-Зүг чигээ олсон зургийг хөдөлгөлгүйгээр өөрийн зогсож байгаа цэг ба газар орон дээр олж харах шаардлагатай зүйлийн томьёолсон тэмдэг хоёрыг дайруулан чиглүүлэгч шугам буюу эсвэл харандааг байрлуулна.

-Чиглүүлэгч шугам буюу харандааны дагуу шагайж харан, энэ чиглэлд жинхэнэ зүйлийг нь газар орон дээр хайж олж болно.

ЗУРАГ АШИГЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС:

Газрын зураг наах ажилд бэлтгэх. Сонгон авсан зургуудыг зөв наах нь маш чухал бөгөөд наахын өмнө тодорхой бэлтгэл ажлуудыг хийх хэрэгтэй. Эхлээд зургийн хуудсуудын захыг зөв огтлоход анхаарах хэрэгтэй. Зургийн хуудасны захыг огтлохдоо зураг хамт огтлохгүй байхад онцгой анхаарна.

Зургийн хуудасны захыг огтлох наахад нэгдүгээр эгнээний наалтын зургийн хуудасны зүүн талыг дараагийн эгнээнүүдийн дээд ба зүүн талын огтлоно. Харин сүүлчийн цувааны зургийн хуудасны зүүн талын бүх эгнээнүүд огтлогдохгүй. Зургийн хуудасны хэрэглэгдэхгүй захыг огтолсоны дараа зохих дэс дарааллын дагуу наана. Зургийн хуудсуудыг эхлээд босоо байдлаар дээрээс нь доош цуваа маягаар наана. Цавуу түрхсэн хуудсаа эргүүлээд дээд талын зургийнхаа зах дээр наана. Энэ үед зургийн ажиллах талбайг цавуудахаас болгоомжлох хэрэгтэй. Үүний дараа зургийн цавуудсан захыг нийлүүлэхдээ зам гол хэвтээ шугам гэх мэт газар орны дүрслэлийг онцгой анхаарч тохируулалж байх нь зүйтэй.

Ажлын зураг нь нэг наалтад 9-12-оос илүүгүй хуудастай байх нь зохимжтой бөгөөд энэ нь ялангуяа хээрийн нөхцөлд ажиллахад тохиромжтой байдаг.

Газрын зураг эвхэх. Энэ нь офицер цүнх, ширээн дээр зургийг тохиромжтой тавих, зургийг бүрэн дэлгэхгүй ашиглах, шаардлагатай районуудыг түргэн олох,

зургийг элэгдлээс хамгаалдаг. Хэрэв танхимд ашиглах бол ажлын зураг нь танхимын ширээний хэлбэр хэмжээтэй тохирч байх хэрэгтэй. Газар орон дээр ажиллах үед ажлын зургийг офицер цүнхний хэмжээтэй тохируулж эвхэх нь зохимжтой. Зургийн нугалсан хэсгийн номын хуудастай адил жигд эргүүлэн үзэхэд бүрэн дэлгэрэхгүйгээр ажиллахад тохиромжтой болсон байх ёстой. Зургийн наалтыг дайруулан эвхэж болохгүй. Нягт нямбай эвхсэн зураг нь ажиллахад эвтэй бөгөөд удаан хугацаанд ашиглах боломжтой.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
дэд хурандаа Б.Сайнболор*

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАД ГАДААД ХЭЛНИЙ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ ҮЙЛ ЯВЦЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

“Хэлтэй бол хөлтэй”
Монгол ардын зүйр цэцэн үг

Дэлхий дахинд даяаршлын үйл явц эрчимжиж улс орон, байгууллага, хамт олон төдийгүй албан тушаалтнууд хоорондоо улам бүр харилцан хамааралтай болж, энэхүү үйл явцын хүрээнд орон орны хүмүүс хоорондын харилцаа идэвхитэй хөгжихийн сацуу дэлхий дахинд түгээмэл ашиглагдаж байгаа гадаад улсын аль нэг хэлийг ашиглаж байна. Улс орны хөгжил дэвшлийг дагаад байгууллагын үнэлэмж, чанар чансаа нь тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагч, хувь хүний мэдлэг боловсрол, ур чадвараас ихээхэн хамааралтай байх болов. Энэхүү урган гарч буй шаардлага нь өдрөөс өдөрт шинэ агуулга хэлбэрээр улам баяжиж, үүнийг дагаад аливаа байгууллагын хүний нөөцийн бодлогод маш ихээр хамааралтай болж байгаа нь бидэнд илт мэдрэгдэх болжээ.

Тавигдаж буй уг шаардлагыг хангаж, орчин үетэйгээ хөл нийлүүлэн алхахад шаардагдах мэдлэг боловсрол, мэдээллээр хангагдан өөрийгөө хөгжүүлэх, улмаар байгууллага, хамт олны ололт, амжилтыг бататгахын тулд зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, боловсролын нэг нь гадаад хэл болж байгаа юм. Манай ард түмний дунд яригддаг “Хэлтэй бол хөлтэй” гэх -үг нь үүний нэгэн илрэл болж өнөөдөр биелэлээ олж байгаа нь та бидэнд өдрөөс өдөрт улам хүчтэйгээр мэдрэгдэх боллоо. Энэ үг гарцаагүй үнэн болох талаар гадаад улс, оронд зорчиж үзсэн хүн бүрээс уншигч эрхэм та ямар нэг хэмжээнд дуулсан бизээ. Гадаад хэл сурахад арьс өнгө, шашин шүтлэг, нас, хүйс, цол, албан тушаал ямар ч ялгаагүй шүү дээ. Гагцхүү тухайн хүний өмнөө тавьсан зорилго, хувийн зохион байгуулалт, өөрийн мэдрэмж, чинхүү хүсэл сонирхол л үүнд хамаатай. Өнөө цагт гадаадад төрөл бүрийн, төрөл мэргэжлийн чиглэлээр энгийн болон цэргийн мэргэжлийн сургуулиудад янз бүрийн хугацаагаар суралцах боломжтой болжээ. Энэ нь тухайн хүнд төдийгүй харьяалагдах байгууллагад нь ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт болдог. Үүнд зөвхөн гадаад хэлийг сайтар эзэмшсэн байх асуудал л тавигдах гол шаардлага болдог билээ.